



БАГАХАНГАЙ ДУУРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

худч оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/У/5

Улаанбаатар хот

Газрын зөрчил арилгах арга  
хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн амьдрах орчныг сайжруулах зорилтын хүрээнд нэгж талбараасаа илүү талбайг хашалсан хашаа, хайсыг татуулах, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай дахь орц, гарц, явган хүний замыг хааж, хөдөлгөөнд саад учруулж байгаа байршлууд, зөвшөөрөлгүй баригдсан болон байрлуулсан обьектыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий байнгын ажиллагаатай Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдамжийн дагуу үзлэг шалгалтыг хагас жил тутам чанартай зохион байгуулан, ажлын явц, үр дүнг эргэн танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 07 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



ГАЗРЫН ЗӨРЧИЛ АРИЛГАХ  
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн  
асуудал хариуцсан орлогч  
Тохижилт худалдаа, үйлдвэрлэл,  
үйлчилгээний хэлтсийн дарга  
Багахангай дүүрэг дэх Цагдаагийн  
хэлтсийн дарга  
Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтсийн  
дарга  
Багахангай дүүргийн Татварын хэлтсийн дарга  
1 дүгээр хорооны Засаг дарга  
2 дугаар хорооны Засаг дарга

Нарийн бичгийн  
дарга:

Газар зохион байгуулалтын албаны дарга

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



**ГАЗРЫН ЗӨРЧИЛ АРИЛГАХ  
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго**

Газрын зөрчил арилгах нэгдсэн арга хэмжээний үндсэн зорилго нь газрын тухай хууль тогтоомж зөрчиж, зөвшөөрөлгүй байрлуулсан зөөврийн байгууламжууд, авто зам болон явган хүний зам хаасан обьектууд, эзэмшил, ашиглалтад байгаа газраа дур мэдэн нэмж сунгасан хашааг буулгах, газар чөлөөлөх зэрэг арга замаар иргэдийн эрүүл мэдээн нэмж барилгажсан аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бурдуулж, дүүргийн нутаг дэвсгэрийн барилгажсан хэсгийн нийтийн эдэлбэрийн гудамж, зам, талбайн ашиглалтыг сайжруулах тохижилт хийх нөхцөл, бололцоог бий болгох, газар эзэмшигч, ашиглагч гэрээтэй иргэн, хуулийн хийх нөхцөл, бичиг баримтын зөрчил арилгахад оршино. этгээдийн гэрээний үүргийн биелэлт, бичиг баримтын зөрчил арилгахад оршино.

**Хоёр. Хамрах хүрээ, хугацаа**

1. Жил бүрийн 04 дүгээр сарын 20-ноос 10 дугаар сарын 15-ны хооронд дүүргийн хэмжээнд газар эзэмшиж, ашиглаж, өмчилж буй иргэн, хуулийн этгээдийн гаргасан зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулна.

**Гурав. Үйл ажиллагааны чиглэл**

1. Нийтийн эдэлбэрийн гудамж, зам, талбайд зөвшөөрөлгүй байрлуулсан зөөврийн байгууламжууд (түц, павильон, граж, контейнер, амбаар зэрэг)-ийг нүүлгэн шилжүүлэх, бичиг баримтын зөрчил арилгах газар чөлөөлөх ажлыг дараах байдлаар зохион байгуулна.

1.1 Зоих зөвшөөрөлгүй байрлуулсан зөөврийн байгууламжуудын судалгааг иж бүрнээр нь гаргаж, фото зургаар баримтжуулан бүртгэл хийх.

1.2 Хашаа хайс, зөвшөөрөлгүй баригдсан өргөтгөл гэх мэт обьектын судалгааг гаргаж үндэслэн хугацаатай мэдэгдэл, албан шаардлага тараах наах арга хэмжээ авч, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулна.

1.3 Зөвшөөрөлгүй баригдсан өргөтгөлийн барилгатай холбогдсон газар чөлөөлөх асуудлыг шаардлагатай тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлүүлэх.

2. Эзэмшил, ашиглалтад байгаа газраа дур мэдэн зөвшөөрөлгүй сунгасан иргэн, хуулийн этгээдүүдийн судалгааг бүрэн гаргаж, фото зургаар баримтжуулах, хугацаатай мэдэгдэл, албан шаардлага хүргүүлэх арга хэмжээ авч, гарсан зардлыг буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ авч ажиллана.

3. Газар эзэмшигч, ашиглагч гэрээтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж илэрсэн зөрчлийг баримтжуулах, арилгуулах талаар газар хэмжээ авах, газрын төлбөрийн үлдэгдлийг барагдуулж тооцоо нийлсэн акт, гэрээ арга хэмжээ авах, газрын төлбөрийн үлдэгдлийг барагдуулж тооцоо нийлсэн акт, гэрээ дүгнэсэн акт хүлээлцэх, мөн хүнд үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагуудаар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг нь хийлгүүлэх, газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны дүгнэлтийг хуульд заасны дагуу гаргуулах албан шаардлага хүргүүлэх гэх мэт

4. Газрын зөрчил арилгах явцад нийгмийн хэв журам алдагдах тохиолдолд Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтсээс тухай бүр шуурхай арга хэмжээ авч, хамтран ажиллана.

5. Судалгаанд хамрагдсан объектуудыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөхөд шаардагдах зардал төсвийн тооцоог гаргаж, санхүүжилтийг тухай бүр зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

6. Чөлөөлөгдсөн газрыг үр ашигтай, зүй зохистой ашиглах, хамгаалах талаар санал боловсруулна. Тухайлбал: батлагдсан өрөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тохижилт, авто зам болон явган хүний зам гэх мэт

7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжид тохижилт хийх, улмаар нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн ашиглалт засвар, үйлчилгээ хамгаалалтыг хариуцаж ажиллахыг шаардаж ажиллана.

8. Захирамжийн хүрээнд зохион байгуулж байгаа ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, иргэд олон нийтийн идэвх санаачилгыг өрнүүлэн татан оролцуулах арга хэмжээ авч ажиллана.

9. Ажлын хэсэг үйл ажиллагааны явцын мэдээллийг тухай бүр танилцуулж ажиллана.

#### **Дөрөв. Хүлээлгэх хариуцлага**

1. Зөрчил гаргасан иргэн хуулийн этгээдэд Газрын тухай хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах

2. Мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлэх, албадан шилжүүлэх, газрыг чөлөөлөх, үүнтэй холбогдон гарсан зардлыг буруутай этгээдээр төлүүлэх.